

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

“Монголын төмөр зам” ТӨХК нь 2019-2022 онд нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Он сар	Хийгдсэн ажил
2019.10.18	Гүйцэтгэх захирлын А/76 тоот тусламж үзүүлэх тухай тушаалаар гэр хороололд амьдардаг ажилчдад түлээ нүүрс бэлтгэх өвөлжилтийн бэлтгэлд зориулан нэг удаагийн мөнгөн тусламж үзүүлэв.
2019	Дорноговь аймгийн Зүүнбаян өртөөнөөс Өмнөговь аймгийн Цогтцэций сум хүртэлх нутаг дэвсгэрт ТТ-3Б төмөр замын трасс дагуу олон тооны гүний усны худгийг барьж байгуулсан бөгөөд бүтээн байгуулалтын ажил дууссаны дараа орон нутагт хүлээлгэн өгөх юм.
2020	Байгууллагат хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын орон тоог бүрдүүлж, тус орон тоон дээр нийт 3 хүн ажиллаж байна.
2020.10.21	Гүйцэтгэх захирлын Б/244 тоот тусламж үзүүлэх тухай тушаалаар гэр хороололд амьдардаг ажилчдад түлээ нүүрс бэлтгэх өвөлжилтийн бэлтгэлд зориулан нэг удаагийн мөнгөн тусламж үзүүлэв.
2020.05.05	Лантуун дохио ТББ Ид шидийн орны хүүхдүүдэд туслах аянд хамт олноороо нэгдэж хандив өргөв.
2021.04.25	ТТ-3Б төмөр замын өртөөдөд нийт 200 модны суулгац тарив.
2021.10.02	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж анхны 50 модны суулгацыг тарилаа.
2021.10.09	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж 100 модны суулгацыг тарилаа.
2021.10.28	Гүйцэтгэх захирлын А/75 тоот Санхүүгийн тусламж үзүүлэх тухай тушаалаар төвлөрсөн халаалтгүй, галлагаатай гэр, байшинд амьдардаг ажилтнуудад 2021 оны өвлийн бэлтгэлд зориулж нэг удаагийн мөнгөн тусламж үзүүлэв.